

“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар:19/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2019.04.05-ны өдрийн 16.00 цагт болов.

“Хүрд “ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн нарийн бичгийн дарга Г.Гантуяа хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 126,725.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 11 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 93,68 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, Г.Алтансүх, С.Мягмарсүрэн, С.Пүрэвжав, Тулгат Чандмань ҮЦК ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Батсайхан, Ч.Лхагваа нарын 11 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, 2019 оны удирдлагын зардлыг батлах
4. Бусад асуудлын хүрээнд: Хийц Увс ХХК-ийн 19,88% хувьцааг зах зээлийн үнээр борлуулах асуудлыг хэлэлцэж батлах

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2018 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, зарим нь брокерийн компаниудад хүргүүлсэн материалтай танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Компанийн 2018 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлттэй танилцлаа. 2018 оны үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилт биелээгүй ч 4,068 тэрбум төгрөгийн борлуулалт, 751,05 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Барилга угсралтын ажлын хувьд 260,4 сая төгрөг, түрээсийн ашиг 77,0 сая, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг 701,5 сая төгрөг, компанийн хэмжээнд ашигт ажиллагааны түвшин 18,46% байгаа нь удирдлага, санхүү ашиг олох тал дээр сайн ажилласныг илтгэж байна. 2018 оны бизнес төлөвлөгөө биелээгүй шалтгааныг Сэлбэ дэд төвийн зуух угсралтын ажил удааширснаас болсон гэж тайлбарлалаа.

Ногдол ашигт нэгж хувьцаанд 550 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Ногдол ашгийн хэмжээ урьд оныхоос өссөнд хувьцаа эзэмшигчийн хувьд баяртай байна. Удирдлагын зардлыг төлөвлөснөөс 0,5 сая төгрөгөөр хэмнэсэн байна. ТУЗ-ийн дүгнэлтээс харахад мэргэжилтэй ажилтнуудыг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд 11 удаагийн сургалтад 4,36 сая төгрөг зарцуулсан байна. Бизнес төлөвлөгөөний борлуулалтын орлого буурсан ч ашгийн хэмжээ нэмэгдсэн байна.

Ажилтнуудын дундаж цалин 10,9%-аар өссөн байна. Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ.

Барилга угсралтын ажлыг гүйцэтгээд олж авч чадаагүй байсан 980,0 сая төгрөгөөс 280,0 сая төгрөгийг олж авч, бусдыг авах талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа юм байна.

Орон сууц барих асуудлыг дэмжиж байна.

“Хүрд-Нарлаг” ХХК-ийн Барилгачин сувилал алдагдалтай ажилласанд дүгнэлт хийж ашигтай ажиллуулах тал дээр анхаарах хэрэгтэй.

Төмөр хийцийн цех, бетон эдлэлийн цехийн бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилтнаар хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа мөн хэвийн явагдаж байгаа юм байна. Ашиглалтгүй байсан цехүүдийн барилгыг спорт зал болгон тохижуулж, ажилтнуудаа чөлөөт цагаараа спортоор хичээллэх боломж олгосон нь сайшаатай байна.

Манай компанийн удирдлага цомхон бүтэцтэй. Компанийн стратегийн удирдлагын бүтцийг бэлтгэх, чанаржуулах, төлөвлөх шаардлагатай байна.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Нэг санал хэлье. Алс хэтийн удирдлагыг авч явах хүмүүсээ сургах, томилох талаар анхаарах

-Хүний нөөцийн асуудалд анхаарах, сургах, төлөвлөх шаардлагатай.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: 2018 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлттэй танилцлаа. Асуулт байна.

1. Компанийн хувьд салбартаа өрсөлдөх чадвар хэр вэ?
2. Алдагдалтай ажилласан нэгжээ цаашид яах вэ?

Хурлын дарга Б.Мөнхбат: Манай компанийн эх суурь 1937 онд тавигдсан. 2017онд бид 80 жилийн ойгоо тэмдэглэсэн. Өрсөлдөх чадварын хувьд жилдээ 10 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх чадвартай, 100 гаруй хүн тогтмол ажлын байраар хангадаг.

Барилгачин сувиллын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч 2018 оны 07-р сарын 1-нээс сувилалд амарсан ахмадуудад олгодог хөнгөлөлтийн санхүүжилтыг зогсоосноос 60-хан хүн амарсантай холбоотойгоор алдагдалтай ажилласан байна. Энэ онд алдагдалтай ажилласан ч сувиллын чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна. Ашигтай ажиллах тал дээр менежментийн арга хэмжээ авна.

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Хүрд компанийн хувьд ижил төрлийн бизнес эрхэлдэг бие даасан олон компани төрүүлэн гаргасан. Эдгээр компаниуд шинэ техник, технологио харамгүй хуваалцдаг, бие биенээсээ суралцдаг, мэдлэг чадвараа дээшлүүлэх, ИТА нарыг чадваржуулах тал дээр хамтарч ажилладаг. Манайхаас гарсан компаниудаас Одкон холдинг ХХК сайн явж байгаа. Шинэ төрсөн компаниудтай холбоотой ажиллахыг эрмэлздэг.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: Бидний үйл ажиллагаа тогтворжсон, барилга угсралтын ажил сайн явж байгаа. 2018 оны бизнес төлөвлөгөө биелээгүй нь ажил, тендер бага авсантай холбоотой. Бидэнд жижиг өрсөлдөгч нар их болж байна. Тендерийн хуулинд өөрчлөлт орж, хамгийн бага үнийн саналтай компанийг заавал шалгаруулахгүй болж байгаа нь сайшаалтай байна. Ажил гүйцэтгэх гэрэ байгуулахад их анхаарах хэрэгтэй юм байна. Бид хийсэн ажлынхаа санхүүжилтыг олж авахын тулд БХБ Яам, Төрийн орон сууцны корпорация шүүхэд өгч байж мөнгөө олж авч байна.

Сувиллын хувьд үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлнэ. Шуурхай зөвлөгөөнийг 7 хоног бүр хийж, ажлаа төлөвлөж яваа. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөгт 3-р сарын 26, 27-нд оролцож, 10-аад хүн ажилд авсан. Солонгос, Япон руу өндөр цалинтай ажилд залуучууд их явж, барилгын салбар мэргэжилтэй ажилчдаар дутагдаж байна.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөнд 6,5 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэхгээр тусгасан байна. Сэлбэ дэд төвийн дулааны станцыг бариад ашиглалтанд хүлээлгэн өгөхөд энэ төлөвлөгөө биелэх боломжтой гэж үзэж байна. Мөн удирдлагын зардалд ТУЗ-ийн гишүүдийн цалинг шинэчлэхээр тусгасныг дэмжиж байна. Иймд компанийн бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Барьж байгаа орон сууцаа хэрхэн борлуулах вэ?

Орон сууцны албаны менежер Б.Ундрах: Өнөөдрийн байдлаар 84 айлын орон сууцнаас 27 орон сууц борлогдсон байгаа. Орон сууцны борлуулалт 5,6,7-р сард өсөх хандлагатай байдаг. Орон сууцны 1м²-н үнэ бодлоготойгоор өндөр талдаа байгаа. Бид чанартай орон сууц барьж борлуулна. Гаражийн хөрөнгө оруулалт

750,0 сая төгрөг байгаа. Газар, гаражийн өртгийг оруулаад 1м2 өртөг өндөр тооцогдож байгаа. Орон сууцыг энэ онд дуусгаж ашиглалтад оруулна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Энэ онд орон сууц дуусахаар дараагийн ээлжинд компанийн газарт төлөвлөж байгаа юу? Хувьцаа задлах, борлуулах тал дээр ямар бодлого баримталж байна. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн үү. Хийлгээгүй бол хийлгэх үү?

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Өнөөдрийн хуралд хувьцаа эзэмшигчийн хувиар ярьж байна. Өмчийн бодит өөрчлөлтгүй, үндсэн хөрөнгө 200,0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Ногдол ашиг 1993 оноос хойш олгож эхэлсэн. Энэ жил нэгж хувьцаанд 550 төг, нийт 74,0 сая төгрөг олгож байгаад таатай байна.

Өнгөрсөн онд боломжийн ашигтай ажилласан. Барилга угсралтын ажлын гэрээний үүргээ биелүүлсэн. Захиалагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн. Сүүлийн үед тендерт өрсөлдөх компаниуд олширсон. Үндсэн хөрөнгөтэй, газартай, олон ажилчинтай компанийн хувьд тендерт оролцоход үнийн дүнг их хасах боломжгүй юм. 2017-2018 онд үнийн дүнгээс 20-23% хасч тендерт орж байна. Ийм үнээр тендер аваад яаж ашигтай ажиллах вэ? Тэрнээс мөнгөө өсгөөд хадгалаад сууж байсан нь дээр байлаа. Удирдлагын аппаратын хувьд 20 гаруй хүнтэй. Жилд газарт 7 сая төлдөг байсан бол шинэ хуулиар 24 сая төгрөг төлөх боллоо. Бүх зардлууд нэмэгдэж байна.

Тэгсэн ч бид ашигтай ажиллах тал дээр анхаарч ажиллана. Улсаас өгдөг хөнгөлөлтийг хассанаас сувилалд цөөн хүн амарсан.

Ашигтай ажиллуулах тал дээр анхаарна. Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлнэ.

2019 онд орон сууц ашиглалтанд оруулж борлуулна. Маркетингийн асуудлыг анхаарч ажиллаж байгаа. Ажилтнууддаа 15 орчим байр 20% хөнгөлөлттэй үнээр олгоно. Орон сууцны борлуулалтаас ашиг орж ирнэ. Татварын шинэ хууль батлагдсан. Үүнтэй холбоотой бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийнэ. Бетон эдлэл, төмөр хийц, сувиллын үйл ажиллагааг бие даалгана. Борлуулалтын 1,5 тэрбум төгрөгийн орлоготой компаниудын татварын 90%-ийг буцаан олгоно гэснийг мөрдөж ажиллана. Ажиллах хүчний асуудал хэцүү болж байна. Уул уурхай сэргэснээр жолооч, экскаваторчид уурхай руу, бусад залуучууд Солонгос, Япон руу явж байна. Барилгын салбарын ажилтнуудын цалинг 2,5 дахин нэмэгдүүлэх байх. Бизнес төлөвлөгөө биелүүлэх тал дээр анхаарч ажиллана.

Тайлан илтгэлд хувьцаа эзэмшигчдийн өмч, ногдол ашгийн асуудал хөндсөн. 2019 онд орон сууцаа борлуулаад хөрөнгөтэй болно. Мөн Сэлбэ дэд төвийн дулааны станцаа ашиглалтад оруулна. 2020 онд энэ хөрөнгөөрөө ямар бизнес хийх талаар бодож суух цаг ирнэ. Одоогийн байдлаар 800,000.0 америк доллараар тоног төхөөрөмж худалдан авахаар байгаа. 200,000.0 америк долларын сэндвич худалдан авахаар гэрээ хийсэн байгаа. 2019 онд том мөнгөний хэрэгцээ ихтэй ч 2020 онд нөхөөд ороод ирэх боломжтой. Ер нь ашигтай ажиллах ирээдүй харагдаж байгаа.

ТУЗ-ийн дүгнэлтийг дэмжиж байна. Батлах саналтай байна.

Нэг асуудал оруулж та бүхний саналыг авах шаардлагатай байна. Бусад асуудлын хүрээнд Хүрд компанийн эзэмшиж байгаа “Хийц Увс” ХХК-ийн 1,131.4 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 35,481,835.0 төгрөгийн үнэтэй 31,361.0 ширхэг хувьцааг зах зээлийн үнээр борлуулах санал оруулж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: “Хийц Увс” ХХК гэж ямар үйл ажиллагаа явуулдаг хаана байдаг компани вэ?

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: “Хийц Увс” ХХК Увс аймагт байгаа. Газар хол учир үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгаагаас хувьцааг зах зээлийн үнээр борлуулах саналтай байна.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2018 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2019 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, Хийц-Увс ХХК-ийн хувьцааг зах зээлийн үнээр борлуулах санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,725.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,725.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
3. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, 2019 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,725.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: байхгүй
Түдгэлзсэн: байхгүй
4. Бусад: Хүрд ХК-ийн эзэмшиж буй “Хийц-Увс” ХХК-ийн нэг бүр нь 1,131.4 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бүгд 35,481,835.0 төгрөгийн үнэ бүхий

31,361.0 ширхэг буюу 19,88% хувьцааг зах зээлийн үнээр борлуулах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,450.0** ширхэг хувьцаа буюу **99,78 %**.

Татгалзсан: байхгүй

Түдгэлзсэн: **0,22 %**.

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.Үүнд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.
4. Хүрд ХК-ийн эзэмшиж буй Хийц-Увс ХХК-ийн нэг бүр нь 1,131.4 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бүгд 35,481,835.0 төгрөгийн үнэ бүхий 31,361.0 ширхэг буюу 19,88% хувьцааг зах зээлийн үнээр борлуулах саналыг дэмжиж батлав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.30 цагт хурал дуусав.


ПРОТОКОЛ ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ГАНТУЯА